



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/62

Ховд

Хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын "в", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, сар шинийн баяр болж байгаатай холбогдуулан Ховд аймгийн нутаг дэвсгэр, сум, орон нутгаас гарах, орох нийтийн болон хувийн тээврийн хэрэгсэл, иргэдийн зорчих хөдөлгөөн, зах, худалдаа, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагааг 2021 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 16:00 цагаас 2021 оны 02 дугаар сарын 16-ний өдрийг дуустал түр хугацаагаар хязгаарласугай

2. Нийтийн болон хувийн тээврийн хэрэгсэл, иргэдийн хөдөлгөөн, зах, худалдаа, үйлчилгээний төвүүдийн үйл ажиллагаанд хязгаарлалт хийж хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Онцгой комиссын орлогч, Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Жаргалант сумын Засаг дарга бөгөөд Ховд хотын захирагч /Ц.Цогтбаяр/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хяналтын пост, цэгүүдийн үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үүрэг гүйцэтгэж байгаа мэргэжлийн байгууллагуудын алба хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулж, хоол хүнс, аюулгүй байдлыг хангуулах заавар, зөвлөмж өгч ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Ховд хотын захирагч бөгөөд Жаргалант сумын Засаг дарга /Ц.Цогтбаяр/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Г.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/62 Ch

02 0535